

## ФИЛОСОФИ, КОМЕДИ БА САЙН МАТЕРИАЛЫН ХЭРЭГЦЭЭ: КВИЛЛ Р.КУКЛА

### Philosophy, Comedy, and the Need for Good Material by Quill Kukla

Орчуулсан: С.Бүжинлхам

Этвөш Лорандын Их Сургуулийн докторант  
МУИС, Философи, шаашин судлалын тэнхим

И.Даваадорж, магистр

МУИС, Утга зохиол, урлаг судлалын тэнхим

**Түлхүүр үг:** Уг өгүүлэлд буй хэд хэдэн санааг буруугаар ойлгож, гөжжүүдлэн, нугалвал маргааны уурхай болж мэдэхээр юм гэх зурвас бодол төрсөн тул уг өмнөтгөл тайлбарыг бичив.

Уг өгүүлэлд буй хэд хэдэн санааг буруугаар ойлгож, гөжжүүдлэн, нугалвал маргааны уурхай болж мэдэхээр юм гэх зурвас бодол төрсөн тул уг өмнөтгөл тайлбарыг бичив. Тухайлбал “Жинхэнэ философи” гэж юу болох тухай хүрээ хязгаар татах нь зонхилох бус бүлгийн гишүүдийн шинэ шинэ бүтээлийг талбарын гадна үлдээж, гарз учруулах юм.” гэдэг өгүүлбэр бий. Өгүүллийг зохиогчийн намтар луу өнгийвөөс яагаад ийнхүү бичсэн нь тун тодорхой болно. Квилл Кукла нь 2023 оны байдлаар Жоржтауны Их сургуульд философийн профессороор ажиллаж байгаа агаад хот төлөвлөлтөөр магистр таа суралцаж буй оюутан юм. Сонирхогчийн түвшинд бокс тоглож, хүндийг өргөдөг гэхээр өгүүлэлдээ дурдсан шигээ баялаг амьдралтай нэгэн гэж хэлж болохуйц. Ёс зүй (бэлгийн зан үйлд холбогдох ёс зүй, өөрийгөө мэдэх хийгээд үйлдэгчийн онол, био ёс зүй, шинжлэх ухааны ёс зүй), хэлний тухай философи, нийгмийн эпистемологи, шинжлэх ухааны философи (газарзүй хийгээд анагаах ухааны философи), дарангуйллын эсрэг философи зэрэг чиглэлээр судалгаа хийдэг нэгэн юм. Энд дурдагдаж буй “дарангуйлал” гэдэг нь уламжлалт гэхээсээ илүүтэй 1960-1970-д оны нийгмийн хөдөлгөөнүүдээс үүдэн баяжсан шинэ утгатай юм. Уг шинэ утга ёсоор: “Дарангуйлал нь цөөн хэдэн хүний сонголт эсвэл бодлогын үр дүн биш харин

бүтцээс үүдэх үйл явц юм. Энэхүү бүтцийг багтаан өргөжсөн утгаар бол дарангуйлал ихэнхидээ ерийн харилцаан дахь сайныг хүссэн хүмүүсийн ухамсаргүй төсөөлөл, таамаглал, хариу үйлдэл, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, соёлд суусан хэвшмэл үзэл, шатлан тогтсон хүнд суртал болон зах зээлийн механизмын бүтцэт шинж буюу товчхондоо өдөр тутмын амьдралын хэвийн үйл явцын үр дүнд зарим бүлэг шаналахад хүргэж буй өргөн хүрээний, гүн гүнзгий нэвчсэн зүй бус байдал” (Young, 2005, p. 97) аж. Тиймээс ч Кукла дуу хоолой нь тэр бүр нийтийн хэлэлцүүлэгт хүрдэггүй, хүрсэн ч дуулдаггүй тэр бүлгийг онцолж дээрх өгүүлбэрийг бичсэн гэж хэлж болох юм.

Гэхдээ Куклагийн уг өгүүлбэрээс философи бол ердийн мэдлэг аль эсвэл хэн нэгний өдөр тутам төрж буй сэтгэгдэл, ертөнцийг үзэх үзэл төдий аж хэмээн яаран дүгнүүзэй. Кукла ч “... философи бол арга, асуулт, бичвэр, оюунлаг мэдрэмжийн хөдөлгөөнт, задгай сүлжээсээс бүрддэг гэж хэлж чадах байна” хэмээн дээр өгүүлсэн буй. “Философи дахь арга бол тухайн философи өөрийн судлах зүйлээ авч үзэхэд болон мэдлэгийн нийт юмуу олон төрөл салбарт баримтлан мөрдөхөөр боловсруулсан сэтгэхүйн дүрэм, шаардлага, зарчим, эв зүйн цогц мөн” (Ц.Гомбосүрэн, 2014, хууд. 31) гэдгийг бодолцвоос философи нь сэтгэгдэл, афоризм, хувь хүний ертөнцийг үзэх үзэл

байж таарахгүй байна. Харин арга нь яагаад “хөдөлгөөнт, задгай сүлжээс юм бэ” хэмээн асууваас “Өөр өөр чиглэлийн философийн үр дүн болсон янз бүрийн философи арга ба аргагүйн хандлага аль аль нь танин мэдэхүйн тодорхой нөхцөлд зохистой байдгийн сацуу өөр бусад нөхцөлд тэдгээрийг баримтлах нь өрөөсгөл байдал, туйлшруулахад хүргэдэг аж. Ийм учраас янз бүрийн философи арга зүй арга хандлага бүгд харьцангуй бие даасан үнэлэмж (value) байдгийн сацуу тэдгээр нь бие биеэ цулгүй үгүйсгэдэг биш, харин бие биеэ шаардаж, нөхцөлдүүлж, харилцан нэгнийгээ нөхөн гүйцээдэг” (Ц.Гомбосүрэн, бас бус., 2000, хууд. 74) ” хэмээн хариулж болох юм. Түүнчлэн философи танин мэдэхүй, үнэлэмж аль алины тодорхой үр дүн болж байдаг учраас “оюунлаг мэдрэмжийн хөдөлгөөнт, задгай сүлжээс” хэмээн хэлэх бололцоотой байна. Мөн өгүүллийн орчуулгыг уншаад шүүмжээ хэлсэн шүүмжлэгчийн “Ер нь постмодернист маягийн үгүйсгэл, чамирхал, моодлолт нь зохиогчийн угтаа зүйтэй санаа, үндэслэлийг бүрхэгдүүлдэг зарим талтай юм шиг надад хувьд санагддаг.” гэх санааг дурдъя. Өгүүлэлд зүйрлэл, адилтгал, егөөдөл харамгүй байгаа нь найруулгын хувьд таатай, харьцуулан бодох бололцоо өргөнөөр олгож буй авч, философийг мөн л хэт хялбаршуулан, махчилан ойлгох нөхцөл бүрдүүлж буй тул хянуур хандахыг зөвлөө.

\* \* \*

Философийн тухай чанд тодорхойлолт өгнө гэдэг бараг л боломжгүй ажил. Манай талбар хатуу тогтсон аргын олонлогийг бус өөр өөр хүрээний, багцаалдан бүлэглэсэн аргад түшиглэдэг. Заримдаа тэдгээр нь бусад талбарынхтай давхцахын зэрэгцээ цагийн аясаар хэрэглээнд орж, гарч байдаг. Тодорхой зорилгод чухамхүү аль нь тохиромжтойг заах дүрэмгүй мөнөөх аргууд задгай нүсэр эх бичвэрт хэргээ дадмаг гаргана. Шинжлэх ухааны ихэнх салбараас ялгаатай нь бидний

(философийн орч.) мэдлэгийн хүрээ хязгаар, байр байдал, багцааны талаар нэгдсэн санал бүү хэл зөвшилцөлд дөхөх хувилбар ч үгүй. Хэдэн төрлийн субстанци байдаг вэ? Ёс суртахуун гэж юу вэ? Чөлөөт хүсэл гэж бий юу? Бид ер нь аливааг мэдэж чадах уу? зэрэг талбарынхаа хамгийн суурь асуулт дээр хүртэл философичид эрс санал зөрөлдөнө гээч. Ер нь философийн асуулт гэж юу вэ гэдэг дээр хүртэл тэр бүр санаа нийлдэггүй юм.

Магад бүр хяслантай нь философи шууд утгаараа сэдэв юм уу, судлагдахуун байхгүйгээрээ мэдлэгийн бусад төрлөөс ялгардаг. Хүслийн уг чанараас эхлээд урлагийг юу сайхан болгодог хүртэл, хүүхэд төрүүлэх нь ёс суртахуунтай үйлдэл эсэхээс иргэдийн улс төрийн эсэргүүцэл, индекс бүхий өгүүлбэрийн формал бүтэц хүртэл, эдгээр эсвэл эдгээрээс бусад юуны ч тухай философидож болно. Юуны ч тухай байж болдог, юунд ч хүлэгддэггүй талбарыг яаж бид тодорхойлж чадах билээ?

Би философийг ойлгох үед л юу болохыг нь мэднэ гэж урьд хэлдэг байсан ч энэ бодлоосоо алхам алхмаар ухарч байгаа. Одоо бол “юуг философи гэж үзэх” тухай интуицид бидний мэргэжлийн бэлтгэл, хувийн онцлог шинж, нийгмийн байр суурь, газар зүйн байрлал зэргээс үүдэлтэй хүрээ хязгаар, гажилт гуйвуулга ул мөрөө гүн үлдээдэг гэж бодох болсон. Эдгээр нь бидэнд тодорхой юу ч хэлдэггүй харин багжиж тогтсон эрх мэдлийн бүтцийг л бөхөлдгөөрөө нэрмээс болдог юм. Энэхүү интуици нь ерөнхийдөө юу “философи шиг санагдаж байгаа”-аас эхлээд уг мэргэжлийг эзэмшсэн этгээдийн тухай байдаг. Гэвч тухайн интуицийг шалгах, нягтлах хэмжүүр байхгүйгээс үүдэн ихэнхдээ өрөөсгөл хандлагыг даамжруулж, ондоо интуицтэй, ялгаатай хүмүүсийн байр суурь, харах өнцгийг хавчин гадуурхдаг.

Би энд философийг тодорхойлохгүй.

Тодорхойлж болно ч гэж бодохгүй байна. Хамгийн сайндаа л философи бол арга, асуулт, бичвэр, оюунлаг мэдрэмжийн хөдөлгөөнт, задгай сүлжээсээс бүрддэг гэж хэлж чадах байна. Философийг тодорхойлохын оронд сайн философидоход шаардлагатай маш чухал урьдач нөхцөл; философийн голчлон гүйцэтгэдэг нэг үндсэн функц; уг талбарт ялгаатай нийгмийн байр суурь бүхий хүмүүс байхын, өөр өөр бие махбод философидохын ач холбогдлын талаар ярьж. Эдгээр санаа нь хоорондоо уялдаатай юм.

Би философи болон стэнд-ап комеди олон талаараа ижил төсөөтэй байгааг бишрээд удаж байна. Онцгойлж ялгах судлагдахуун байхгүй гэдгээрээ комеди философитой ижил. Ер нь юуны ч тухай хошигнож болдог. Философич болон комедич нар нүдний маань өмнө ил байж л байдаг ч огт анзааралгүй өнгөрөөдөг, ертөнцийн аль нэг талыг онцолж бодит байдал гэж юу болохыг цоо шинэ өнцгөөс дүрслэх хүчир, бараг боломжгүй даалгавартай улс. Философич хийгээд комедич нар хэвийн хэмээн хүлээж авдаг нуугдмал төсөөллийг төнхөн гаргаад, бидний өдөр тутмын нөхцөл байдлыг сониуч харцаар харж, шүүн шинжлэхүйц үнэ цэнтэй эд гэдгийг харуулдаг. Аль алинд нь бэлтгэл, сургуулилалт чухал төдийгүй комеди нь философитой адил яг таг тогтсон аргагүй, амжилтад хүрэх нийтлэг хэм хэмжээгүй. Комеди хөгжилтэй байх ёстой гэсэн хэмжүүртэй байх ёстой эсэх нь ч бүрхэг. Дөнгүүр зарим комеди чимх инээд дагуулахаасаа илүүтэй бараан өнгө аястай байж, бодлогошролд хөтөлдөг билээ.

Философи ч комеди ч аль аль нь ялгарах судлагдахуунгүй, юуны ч тухай байж болдог тул уг хоёр талбарт ямар нэг юмны тухай байх шаардлага тулгарч, философичид ч комедич нарт ч материал хэрэг болдог. Бид комедичид материал хэрэгтэй гэж хэлдэг дээ. Гэтэл философичид ч материал хэрэгтэй.

Чухамхүү бүхэл ертөнц ээдрээ нугачаатайгаа тэр аяараа бидний сэдэв байдаг учраас л философич бид, хийгээд комедич нар ажлаа эрхлэхийн тулд орчлонтой тулж харьцаж, өнцөг булан бүрээр нь хэсүүчилж, хэсэг тал бүрд нь хуруу дүрж явах учиртай.

Цаг уурын тухай зүй ёсны үзэл болон арьстны тухай бичдэг Олуфемий Тайво ярилцлагынхаа үеэр хөгжимчин гэх удаах мэргэжлийнхээ тухайд “Философиос гадна өөр нэг зүйлд гүнзгий автах нь намайг илүү сайн философич болгодог гэж боддог. Ертөнцтэй шууд харьцахын оронд талбар хийгээд эх зохиол руу л өндийж хардаг зуршилд автах тун амархан. Гэтэл тухайн талбар, өнөөх ном бүтээлийн хайгаад байгаа хариултууд чухамхүү орчлон дээр буцалж, бидний өгсөн хариултын давлагаатай нүүр тулах хүмүүс тэнд л амьдарч байгаа шүү дээ” хэмээсэн байдаг. Сайн, санаа оноогоор баялаг, сонирхолтой философи бусад философид хариулахаас илүүтэй ертөнцөд хариулдаг гэдэг сууриараа тун чухал санаа юм. Ертөнцийн тухай хариу өгөхийн тулд тэнд хөл тавьж, цаг гаргаж хорвоотой “барьцалдах” хэрэгтэй гэдэг Тайвогийн үзэл ч мөн чухал. Философид угаас дангаар нь авч үзэх судлагдахуун үгүй тул зөвхөн философид цагаа зарцуулж, анхаарлаа хандуулах аваас муу философич л болж хоцорно. Дотнын танил маань онгоцоор аялах тухай л хошигнол хэлэх болсон комедичдын тухай гомдоллож билээ. Тэд хорвоогийн тэр хэсгийг л харах болсон байж. Сайн комеди хошигнохоос гадна, өнгө өнгийн баялаг амьдралаар амьдрахыг шаардана. Тэгж байж түүнийхээ тухай хошигноно шүү дээ. Философи ч мөн адил. Хүний хувьд уйтгартай нэгэн байж, бүх л амьдралаа органик молекулыг судлахад зориулсан ч тухайн хүн сайн молекул биологич эсвэл хором бүрээ цаг урлахад зарцуулдаг ч сайн цагчин байж болно. Гэтэл философичдод тусгай судлах судлагдахуун үгүй тул хэрэв бид мөч бүрээ

философидоход зарцуулах аваас, бусад философид л хариулдаг, өөрөө өөрийгөө л дурддаг оршихуй болж, ертөнцийн гайхам талыг дэлгэн харуулж чадахаа байна.

Комеди хошигнолыг үндсэн багажаа болгож ертөнцийн аль нэг хэсгийг ондоо өнгөөр харуулдаг. Философийн үндсэн багаж юу вэ? Эдгээрийг тусгайлан тодорхойлох боломжтой гэж бодохгүй байгаа ч хувьдаа гайхан шагширч, онцлон харж, чухалчилж үздэг нэгэн арга бий. Үүнийг дэнатуральчлал гээ. Бид бараг бүгд ертөнцийн суурь бүтцийн тухай янз бүрийн зүйлд бүрэн дүүрэн итгэхийн сацуу, төсөөлд маань бат нут суусан тул тэдгээр үнэмшилд зөвтгөл хэрэгтэй болохыг ч анзаардаггүй. Эдгээр үнэмшлийн дагуу ертөнцийн талаарх жирийн/natural баримтууд нь эртнээс л, “төрөлхөөс/naturally” ийм байсаар ирсэн зүйлс тул зөвтгөл юм уу нягтлал шаардлагагүй байдаг. Философийн түлхүүр функцийг нэг бол энэхүү төрөлхөөс л өгөгдсөн мэт зүйлсийг барьж авч дэнатуральчлах явдал юм. Өөрөөр хэлбэл тэдгээрээс хангалттай зай авч, нэвт шувт асууж, нарийн тайлбар, нямбай зөвтгөл хийх шаардлага байгааг илчилнэ гэсэн үг. Цагийн урсгалд өмнөхтэйгөө ижил хэвээрээ байгаагаа хэрхэн мэдэх вэ? Би би хэвээр байна гэдэг нь юу гэсэн үг вэ? Ёс суртахууны үнэн байхын тулд Эзэн тэнгэр хэрэгтэй юу? Жендертэй байна гэж юу вэ? Энэ нь тодорхой төрлийн биетэй байхтай хэрхэн холбогдох вэ? Бид яагаад хуулийг дагах ёстой вэ? гэх мэт асуултыг философичид асуудаг. Философийн эрэл хайгуулгүйгээр эдгээр нь асуулт болон босож ирэхгүй байх нь олонтоо. Би хийгээд ёс суртахууны үнэний тухай ойлголтуудыг маань хэдэн зууныг дамнасан индукц тодорхой туршлага, үзэл суртал руу хэвжүүлэн мөлийлгөж, хөшигний ар луу шидчихээд асуултуудыг хариултаа олсон төдийгүй угаас асуулт ч биш болгон хувиргадаг талбарт биднийг хашчихдагаас

энэ бүхэн улбаатай. Үүний нөлөөг тайлахыг дэнатуральчлал гээд байгаа юм.

Гайхаж асуулт асуух шаардлагатай гэдэг нь огт анзаарагддаггүй өдөр тутам байдаг л нэг дүр зурагт автсанаар эхэлж, дараа нь тэндээсээ сэрхийн босож, уг дүр зураг нь төрөлхөөс өгөгдмөл гэхээс илүүтэй түүхэн байдлаар нөхцөлдсөн туршлага, нарийн ээдрээт, ихэнхдээ дотооддоо зөрчилтэй байх үзэл санааны цогц болохыг дөнгүүр сайн философи илчилдэг. Бид дэнатуральчлахын тулд өөр өөр өвөрмөц арга техникийг хэрэглэж болно. Энд далд нуугдмал төсөөллийг ил болгох; өөр хоорондоо орооцолдон бүдгэрч, үр нөлөөтэй шүүж харахын аргагүй, замбараагүй болсон ойлголтуудыг салгаж ялгах; аливаа үзэл санааны түүхийг өгөгдмөл, түүхэн дарааллаар бус харин идеологийн нөлөө, санамсаргүй нөхцлөөс урган гарч буй байдлаар нь мөшгөн тайлбарлах багтана. Комедич өөрийн биеэр үзээгүй зүйлийн тухай яриад түмний инээд хүргэж дөнгөхгүй л болов уу. Үүнтэй ижил үзэгдлийг дэнатуральчлахын тулд философич түүний тухай арвин туршлага, гүнзгий ойлголтой байх хэрэгтэй. Бид алив зүйлийг нэвтэрхий ойлгож байж л эмтэрхий хагархай, бололцоо тохиол, нуугдмал хэлбэр, нүдэнд үл харагдах бүтцийг нь олж чадна.

Философи хийгээд дэнатуральчлал нь орчлонгийн тухай арвин туршлага шаардлагийг бодолцох аваас газар газраас ирсэн, өөр өөр дүр төрх, авьяас чадвар, жендер, шашин шүтлэг, эдийн засгийн нөхцөл байдал бүхий түмэн янзын хүн философидох нь чухал болохыг харуулах хэд хэдэн шалтгаан гарч ирнэ. Ер нь бол хоёр шалтгаан л даа. Нэгдүгээрт ялгаатай гарал үүсэл, бие махбод, онцлог шинжтэй хүмүүс ертөнцийн өөр нэг хэсэг, ондоо нэг хэмжээсийг тус тусдаа үзэж туулсан байдаг. Иймээс гэдэнд эрс тэс, өөр өөр философийн материал байна гэсэн үг. Хоёрдугаарт

аль хэм хэмжээ, ямар санаа “төрөлх” мэт санагдах эсэх нь бид тэдгээртэй ямар байр сууринаас хэрхэн харьцаж байгаагаас хамаардаг. Тиймээс ялгаатай ялгаатай хүн, өөр өөр зүйлийг дэнатруаль болгохдоо гаргуун байж мэднэ. Би уг нотолгоогоо дэс дараатайгаар, жишээ баримт татан үндэслэе.

Ертөнцийн тухай ялгаатай туршлага философийн шинэ материалын сурвалж болж, философид шинэлэг асуулт дэвшүүлдэг талаар хэд хэдэн жишээг эхний ээлжидавчүзье. Удаанхугацааны туршхүүхэд нас, жирэмслэлт, бусдыг асран халамжлах үед зарцуулдаг биеийн хөдөлмөрийг тухайлан анхаарсан философийн бүтээл үгүй байв. Энэ нь өнөөдөртэй харьцуулахад урьд урьдын цаг үед эрчүүд философид давамгай байсантай холбоотой байж мэднэ. Асарч халамжлах үүрэг хүлээж, жирэмсэлж бас нярай хүүхэд асардгийнхаа хувьд эмэгтэйчүүд дуу хоолойгоо мэргэжлийн хүрээнд илүүтэй хүргэх болсон. Ийн биеэр асарч сувилах хөдөлмөр болон бусад ажлын холбоо, хүүхэд, нярайн үйлдэлдээ эзэн болох үйлдэгч чанар хийгээд ёс суртахууны статус, ирээдүйн хүмүүний амь амьдралыг хариуцаж буй жирэмсэн эмэгтэйн бие даасан байдал гэж юу болох талаар зэрэг философийн цоо шинэ асуулт, асуудлуудын хүрээг тэд нээв.

Бас нэг жишээ дурдъя л даа. Европ болон хойд Америкаас гаралтай цагаан арьст философичид англи хэлт философийг урт удаан хугацааны турш ноёлсоор ирсэн. Гэвч сүүлийн жилүүдэд колоничлогдож байсан Африк, Ази болон өмнөд Америкийн орнуудаас угшилтай эрдэмтэд колоничлол нь улс төр болон соёлын үзэгдэл болох талаар хөндөж, философи эргэцүүллийн нэгэн талбарыг гаргаж ирлээ. Постколоницлолын философи үүссэнээр деколоничлолд юу юу багтвал зохистой, колоничлогч улсууд колоничилж байсан орныхоо өмнө хүлээх хариуцлага зэргийн талаар норматив асуулт тавих боломжтой болов.

Мөлжлөг, соёлыг зохисгүй ашиглах явдал, хэт их хэрэглээ зэрэг колоничлолын онцгой шинж болдог тодорхой үйл явц хийгээд колоничлол хэрхэн хувь хүний онцлог шинж болон үйлдэгч чанарт нөлөөлсөн талаар эргэцүүлэх ойлголтын орон зай, төрт улсуудын хоорондын харилцааны тухай уламжлалт философи загварт байдаггүй. Хэдийгээр дэлхийн хүн амын зонхилох хувь аж төрж буй орнууд нэг бол колоничлогч эсвээс колоничлогдож байсан эс бөгөөс аль аль нь хамаарч байдаг ч байдал ийм л байна.

Нийгэмд ноёлох байр суурь эзэлдэг хүмүүс нийт хүн амтай харьцуулахад цөөнх байдаг. Гэвч тэд институци болон хэм хэмжээг тогтоодог тул ертөнцийн үлэмж хэсэг нь тэдний харах өнцөг, хэрэгцээнд тааруулан боссон байдаг. Үүнээс үүдэн тэдэнд тохиож буй санамсаргүй туршлага жирийн баримт мэт ойлгогдохын сацуу ондоо төрлийн туршлага хараанаас гадна үлдэж эсвэл мэдэхэд бэрх болж таардаг. Маркс идеологи бол ноёлох бүлгийн амьдралын хэвшлийг “жирийн” мэт харагдуулж, ашиг сонирхлыг нь хамгаалдаг нийгмийн институт болон хэм хэмжээг бүтээхээр загварчлагдсан хэмээн үздэг. Сонгодог жишээ гэвээс язгууртнуудын “цус” онцгой, цагаан арьстнуудын “ген” гойд гэх зэрэг нь аль аль бүлэгт нийгмийн асар том давуу тал, нөөц боломж олгож, уг тэгш бус байдлыг дархлаажуулдаг. Үүнтэй ижил чөлөөт зах зээл бол (нөөцийг нийтэд хуваарилахдаа ямар зохион байгуулалтыг баримтлах тухай нэг хүний сонголт гэхээсээ илүүтэй) зүй ёсны зохион байгуулалт, шударга ёсны найдвартай зууч гэх санаа нь капитализмыг төрөлхийн шинжтэй болгож, цалинтай ажилчдад бус бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг эзэмшигчдэд үр өгөөжөө өгдөг.

Ийм учраас ноёлох хэм хэмжээнээс ялгаатай хувийн онцгой шинж, нийгмийн байр суурь, бие махбодтой хүмүүс хэм хэмжээ, үзэл санааг дэнатуральчлахад тун

тохирсон цэгт байгаа юм. Философич хэвийн бус биетэй, зонхилох бүлгийн нэг биш бол өнөөх жирийн хэм хэмжээ, идеологитой харьцах ондоо буланд зогсож байна гэсэн үг. Туршлага нь бодит байдлын тухай жирийн, нэгэн хэвийн ойлголттой нийцэхгүй учир тэд уг ойлголтыг санамсаргүй хэмээн үл харж, шүүмжлэлтэйгээр шинжлэх хэрэгцээг анзаарахдаа дадамгай. Энэ байдал нь хэвийн хэм хэмжээ, идеологид өлгийдүүлсэн бүлгийнхний олж харж чадахгүй чухал чухал философи санааг илрүүлэхэд ивээс болдог.

Жишээлбэл улс төрийн холбоо хийгээд эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн нэгж болдог парадигматик нэгэн бол бие махбодын хэрэгцээ гэж үгүй, бие даан бүрэн шийдвэр гаргах эрхтэй хувь хүн юм гэж үеийн улс төрийн философичид үзсээр ирсэн. Бүх улс төр хийгээд эдийн засгийн онол маань улс төрийн онолын “төрөлх” нэгж болсон хүний тухай тэрхүү загвар дээр суурилсан. Гэтэл бага насны хүүхэд хардаг эмэгтэйчүүд, тусгай хэрэгцээт хүмүүс болон тэдний асран хамгаалагчид зэрэг сая сая хүн уг загварт багтдаггүй гэдэг нь тодорхой. Биеэ даасан байдлын өнөөх загварт багтдаггүй, хувь хүний шинж, хэрэгцээ нь уламжлалт онолд тэр бүр тусгалаа олдоггүй бүлэгт хүүхэд, хөгшид, амьдрахад нь бусдын тусламж хэрэгтэй байдаг бие эсвэл оюуны хэвийн бус чадвартай хүмүүс багтдаг. Тусгай хэрэгцээт хүмүүс, асран халамжлагчид философидож, дуу хоолойгоо хүргэж эхэлмэгцээ тэд зөвтгөл хэрэггүй, жирийн мэт харагдах урьдач

нөхцөл, ерөнхий төсөөллийг шүүмжилж, дэнатураль болгож, улс төрийн онолыг эрс шинэчилсэн юм. Уг эрдэмтэд уламжлалт загварт нийцэхгүй байх нь хэм хэмжээнээс гажсан хазайлт биш, харин ч эмзэг байдал, хязгаар хүрээ, нийгмийн холбоо зэрэг нь хүн байхын гол шинж тал болохыг тод томруунаар олж харсан аж.

Өөр нэгэн жишээ гэвээс сизжендер<sup>1</sup> хийгээд жендерт нийцдэг философичдын хувьд хүйс, бэлгийн чиг баримжаа, жендер зэрэг нь бүгд “төрөлх”-өөс өгөгдсөн, биеийн харагдах байдлаас л шууд уншиж болохуйц гэх асуулт хэрэггүй, хэн хүний мэддэг баримт байв. Гэхдээ транс, күйр болон жендерийн хэвшмэл байдалд үл нийцэх<sup>2</sup> бусад хүн (жишээлбэл хүйсээ сольж хувцасладаг хүмүүс орч.) тухайн итгэл үнэмшлийг төрөлхийн баримт гэхээс илүү нийгмийн тулган шаардалт хэмээн хүлээн авдаг. Тэд хүйс, хүйсийн баримжаа, жендерийн тухай арай аядуу, торгон, дэнатуральчлал бүхий философи байр суурьд орон зай нээж өгдөг.

Ерөнхийдөө тусгай хэрэгцээт, жендерийн хэвшмэл байдалд үл хамаарах, тарган эсвэл цагаан арьстан бишээсээ шалтгаалан ялгаварлуулдаг хүмүүс биеийнхээ тухай болон бие махбод нь бусадтай харьцуулахад ялгаатай гэдгийг мартаж боломж ер олддоггүй. Бидний институт цагаан, сиз, хөгжлийн бэрхшээлгүй, туранхай биед орчин нөхцөлөө яв цав тааруулан, үүнд холбогдох нийгмийн үйлдвэрлэлийг нүднээс далд тавьчихдаг. Тэд автобус, онгоцны суудалд асуудалгүй сууж,

<sup>1</sup> Жишээ нь 2009 онд философийн үндсэн асуудлын талаар философичдоос авсан өргөн хүрээний судалгааны үр дүнг <https://philpapers.org/surveys/results.pl-aac> үзнэ үү. Аль ч сэдвийн тухай нэгдсэн зөвшилцөлд хүрээгүй байгаа болно. Чадагч тэнгэр гэж байхгүй гэх үнэмшилд л санал нэгдэх дөхөж гэж хэлж болох юм. Гэхдээ энэ нь дийлэнх олонх нь ийнхүү санал нэгдсэн ч хэрэг бас биш. Цаашилбал асуулт бүрт “бусад” гэж хэдэн философич хариулсан нь ч бас нэг дохио. Бусад гэсэн хувилбарыг сонгоно гэдэг нь эдгээр асуултыг хариулахуйц эвтэйхэн томъёолоогүй байна гэдгийг илэрхийлж буй хэрэг. Бид асуултад ч санал нийлж чадахгүй байхад хариултын тухайд дурдаад ч хэрэггүй биз ээ. Уг судалгааг авах үед маш олон философич чухалчилж үздэг асуултауд маань асуултад багтаагүй байна хэмээн гомдоллож байсан юм.

<sup>2</sup> Индекс бүхий өгүүлбэр гэдэг нь би, чи, бид, одоо, маргааш, гэх зэрэг хаана, хэн, хэзээ хэрэглэж байгаагаас тухайн үгсийн утга, референт нь хамаардаг өгүүлбэр юм. Зарим философич хэлний прагматик талыг судлахдаа зөвхөн индекс бүхий өгүүлбэрээр хязгаарлах нь бий. Орч.

мэргэжлийн дэг шаардлагыг хялбархан биелүүлж, гудмаар алхахдаа хараа хяналтад үл өртөж, ажиг сэжиг төрүүлдэггүй. Норматив бие нь орчиндоо яг таг таарах тул ийм биетэй байхад нэг биеийг нөгөөгөөс төвлөн илүүд үзэж, давуу эрх олгодог туршлагыг санамсаргүй тохиол гэхээсээ илүүтэй юмс “төрөлхөөс ийм л” байсаар ирсэн гэж харах шиг амархан зүйл үгүй.

Танин мэдэхүйн онол, оюун санааны философи, нийгмийн философийн хүрээнд норматив биш биетэй философичид өөрсдийн биеэр туулсан буюу нэгдүгээр биеийн туршлагадаа суурилан хүрээлэн буй орчин хийгээд нийгмийн хэм хэмжээг дэнатураль болгодог. Тэд хэрхэн сэтгэх, мэдэх, бусдаар үнэлүүлэх, ямар боломж бидэнд олдох, нийгмийн хэм хэмжээ бидний “би” гэх ойлголтыг хэрхэн хэлбэржүүлдэг болон бусад түм буман зүйлсэд бие махбод маань хэр чухал, хэчнээн санамсаргүй үүрэг гүйцэтгэдгийг ил тод харуулдаг билээ. Энэ нь философи судалгааны бүхэл бүтэн шинэ талбарыг нээж, философийн шинэ шинэ ойлголт бүтээсэн юм. Жишээлбэл Патриша Хилл Коллинс мэргэжлийн туршлага юм уу дэвшүүлж буй зөвтгөлийн чанар төдийгүй арьс өнгө, жендер маань бусад хүн биднийг найдвартай танин мэдэгч, баталгаатай мэдүүлэгч гэж харах эсэхийг, хэзээ тэгж харах вэ гэдгийг шийдэхэд нөлөөлдөг гэж нотолдог.<sup>3</sup> Алисон Рейхелд тэргүүтэй судлаачид эмнэлгийн нөхцөлд тарган биеийг итгэл даахгүй гэж үздэг агаад энэ нь сүрхий хорон нөлөөтэй болохыг баталжээ.<sup>4</sup> Норматив биш биетэй эрдэмтэд иймэрхүү танин мэдэхүйн чадварыг нь үнэлсэн үнэлгээ хийгээд таагүй нөхцөлтэй

өдөр бүр л нүүр тулж байдаг. Хэнд итгэхээ шийдэх цорын ганц зам нь хэлсэн үгийнх нь найдвартай эсэхийг цэгнэх явдал гэдгийг “хэвийн” хэмээн үзэж байсан цагаан арьстай, тусгай хэрэгцээт бус, сиз эрчүүд философид давамгайл байх үед тэд аниргүй байлаа.<sup>5</sup>

Энд ахиад л философид тулгарч буй зүйл комедид ч таарч байна гэж болох юм. Комедичид эртнээс л янз янзын бүлгийнхнээс бүрдсээр ирсэн. Өөр өөр арьс өнгө, биеийн хэлбэр, жендертэй хүмүүс тодоор гялалзаж, амжилттай байсан. Төрөл бүрийн хүмүүс комедиг баяжуулсан чухамүү тэр шалтгаан нь философид олон янз байдал хэрэгтэй гэх үндэслэлтэй нягт холбоотой гэж таах юм. Гэхдээ энд комеди онол боловсруулах би хэн билээ.

Сайн философи бол зөвхөн бусад философитой төдийгүй хорвоотой “ноцолдох” хэрэгтэй аж. Ертөнцтэй харилцах харилцаа нь өөр байж, ихэнхдээ хөшигний ард байх асуулт, ухаарлыг татан гаргадаг тул өнгө өнгийн харах өнцөгтэй, ялангуяа ноёлох биш хувийн онцлог шинжтэй, норматив бус бие махбодтой хүмүүсийн дуу хоолой философид хэрэгтэй. Философичид илүү баялаг, бүгдийг багтаасан бүлэг болох тусам философийн сэдэв, арга, асуулт, судлагдахуун аажмаар хувирна. Оюун санааны утгаараа энэ бол эрүүл явдал. “Жинхэнэ философи” гэж юу болох тухай хүрээ хязгаар татах нь зонхилох бус бүлгийн гишүүдийн шинэ шинэ бүтээлийг талбарын гадна үлдээж, гарз учруулах юм. Эндээс харахад философийн тухай хатуу чанд тодорхойлолт өгөх нь нэмэргүй, муйхар явдал гэж хэлж болно.

3 Дэн Стэйнбергэд энэхүү олж харсан өнцөг/гомдолд нь талархья.

4 Маркс, Карл., Фрдрих Энгельс, Герман идеологи I боть. Интернэшнл публеширс Ко, 1865/1970. (Marx, Karl, and Friedrich Engels, *The German ideology. Vol. 1, International Publishers Co, 1865/1970.*)

5 Энд би гүнзгийрүүлэн тайлбарлахгүй ч, энд дурдсан хэн ноёлох идеологийн дагуу харах бололцоотой байна вэ гэдэг бол байр суурийн танин мэдэхүйн онолын гол санаа юм. Байр суурийн танин мэдэхүйн тухай сайн тойм уншъя гэвэл дараах бүтээлийг зөвлөе. Интэмэнн, Кристен “Фемнист эмпирицизм ба байр суурийн онолтой 25 жил: Бид өдгөө хаана байна вэ? *Xunatua* 25.4 (2010): 778-796. (Intemann, Kristen, “25 years of feminist empiricism and standpoint theory: Where are we now?” *Hypatia* 25.4 (2010): 778-796.)